Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Хишигдэлгэр Даваадорж

## 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хөрш орнуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн чиглэлийг тодорхойлж, шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих; | | | | | | | |
| 1 | Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнүүдийг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан ба бусад төсөл, хөтөлбөрүүд болон Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан эрэмбэлж хэрэгжилтийг нь эрчимжүүлэх ажлыг зохион байгуулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | Эдийн засгийн коридорын хөтөлбөрийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах тухай 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/2220 тоот албан бичгийг холбогдох яамдад хүргүүлсэн. | Төсөл, арга хэмжээнүүд холбогдох баримт бичгүүдтэй уялдан эрэмбэлэгдэж, хэрэгжилт нь хангагдсан байна. /100 хувь/ | "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн шинэчилсэн жагсаалтыг талууд харилцан баталсан тухай холбогдох яам, газруудад мэдэгдэн жагсаалтыг хүргүүлж, тухайн байгууллагын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг цаг хугацаа, хүрэх үр дүн, шаардагдах санхүүжилт, техник эдийн засгийн үндэслэл, Монгол | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд болон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан байдал, салбарын онцлогт тохирох бусад шалгуур үзүүлэлт тус бүрээр боловсруулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг тус яамны 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/282 тоот бичгээр чиглэл болгосон. Уг албан бичгийн хариуг ГХЯ, ЭМЯ-наас ирүүлсэн бөгөөд бусад байгууллагын холбогдох ажилтнуудаас мэдээлэл авч нэгтгэн эрэмбэлж байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас Бүсийн зөвлөлийн хуралдааныг шат дараатай зохион байгуулж буйтай холбогдуулан Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнүүдийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлэхэд оролцоотой, хамаарал бүхий бүсийн хуралдаанд танилцуулах, төвийн болон орон нутгийн удирдлагыг мэдээллээр хангаж үйл ажиллагааг уялдуулах талаар ажиллаж байна. | | |
| 2 | Эдийн засгийн коридорын хөтөлбөрт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудын ажлын уялдааг хангаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний ажлын хэсгийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | Ерөнхий сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 123 тоот захирамжаар Үндэсний ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. | Холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа хангагдан Үндэсний ажлын хэсгийн хуралдаан тогтмолжсон байна. /100 хувь/ | Эдийн засгийн коридорын хөтөлбөрт хамрагдсан байгууллагуудын холбогдох ажилтнуудтай ажил хэргийн холбоо тогтоож мэдээлэл солилцон ажиллаж байгаа боловч тэдгээрийн оролцоо харилцан адилгүй байна. Иймд тэднийг аль болох идэвхтэй оролцуулж, үйл ажиллагааг уялдуулах, Үндэсний ажлын хэсгийн хуралдааны бэлтгэлийг хангахад санал бодлыг нь тусган хамтран ажиллахад анхаарч байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |
| 3 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван улсын хамтын ажиллагааны уулзалт, ажлын хэсгийн хуралдааны бэлтгэлийг | Уулзалтын тоо | Талуудын Хамтарсан ажлын хэсгийн 6 дугаар хуралдаан 2023 онд, гурван улсын төр болон Засгийн | Гурван талын бүх түвшний уулзалт, ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулсан байна. /жилд 1 | Аугаа их Эх орны дайны ялалтын 80 жилийн ойн баярт оролцох үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ОХУ-ын Ерөнхийлөгч | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангахад дэмжлэг үзүүлж, тухай бүрд нь зохион байгуулна. | | газрын тэргүүн нарын уулзалт 2024 онд тус тус болсон . | удаа/ | В.В.Путин, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нартай хийсэн уулзалт, 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Бээжин хотноо болсон Монгол, Орос, Хятадын Гадаад харилцааны дэд сайд нарын VI уулзалт ярианы сэдвүүдэд Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаарх саналуудыг бэлтгэж өгсөн. Гадаад харилцааны дэд сайд нарын уулзалтын үеэр талууд энэ оны 9 дүгээр сард БНХАУ-ын Тяньжинд болох ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр хийх гурван улсын Төрийн тэргүүн нарын уулзалтыг бэлтгэх ажлын хүрээнд Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийн чухлыг харилцан тэмдэглэсэн бөгөөд монголын тал Төмөр замын төв коридорыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-г нэгтгэхийг түргэвчлэх, байгалийн хийн хоолойн төслийг | сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЭЗК-ын тэргүүлэх төслүүдийн нэг болгож, түүнийг хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг байгуулж гурван талт уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулах, Төмөр замын зүүн коридор байгуулах боломжийг судлах ажлыг эрчимжүүлэх, олон улсын авто замын сүлжээгээр дамжих транзит тээврийг нэмэгдүүлэх зорилгоор хилийн боомтуудын ажиллах горим, дэд бүтэц, хүчин чадлыг харилцан уялдуулах чиглэлээр хамтран ажиллах, Улаан-Үүд-Наушки-Сүхбаатар-Сайншанд-Зүүнбаян-Ханги-Мандал-Бугат-Ордос-Ши-Ань хүрэх төмөр замын холболтын боломжийг судалж шийдвэрлэх, Сүхбаатар-Хөшигийн хөндий-Номгон-Ханги чиглэлд хоёр дахь гол замыг барих төслийг хэрэгжүүлэх зэрэг саналтай байгаагаа илэрхийлсэн болно. | | |
| 4 | Хөтөлбөрийн төсөл, арга хэмжээг | Хэрэгжилтийн явц, хувиар | Талууд 2024 оны 11 дүгээр сарын | Төсөл, арга хэмжээний | Эдийн засгийн коридорын хөтөлбөрт | 1-р сар, 2-р сар, 3-р | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэхэд шаардагдах ТЭЗҮ боловсруулах, санхүүжилтийг нь шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хөрш орнуудтай тохирно. | | байдлаар нийт 33 төсөл, арга хэмжээг тохирсон. | жагсаалтыг шинэчлэн тохирсон байна. /100 хувь/ | туссан төсөл, арга хэмжээнүүдийг хариуцсан байгууллага тус бүрээр нь хэрэгжилтийг нь гаргуулахаар ажиллаж, тэдгээрээс ирүүлсэн мэдээллийг нэгтгэн явцыг нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар гаргасны дээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг бэлтгэв. Мөн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ЗТЯ-аас цахимаар зохиосон "Төмөр замын төв коридорыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах боломжийг судлах" төслийн ТЭЗҮ-г нэгтгэх талуудын шинжээчдийн уулзалтад оролцсон. Түүнчлэн "Томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 27 дугаар тогтоолын хүрээнд ажиллах Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд нарын дунд Эдийн засгийн коридорын | сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрийг болон ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хийн хоолой барих төслийг хариуцсан Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд нар томилогдон ажиллаж байна | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Сургалт, семинар, хэлэлцүүлэг, мэдээллийн цагт оролцоно. | Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд зохиогдох сургалт, семинар, хэлэлцүүлэг, мэдээллийн цагт оролцоно. | - | Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд зохиогдох сургалт, семинар, хэлэлцүүлэг, мэдээллийн цагт оролцсон байна. | 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр яамнаас зохион байгуулсан "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийн төслийн хэлэлцүүлэг, 04 сарын 18-ны өдөр Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай Голомт банкны ажилтнуудын хийсэн сургалт, 01 дүгээр сарын 24-ний өдрийн "Үндэсний ШУТ, инновацийн тогтолцоо ба стратеги" сэдэвт мэдээллийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 90% |

22

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | стратеги" сэдэвт мэдээллийн цагийн арга хэмжээнүүд болон 03 дугаар сарын 27-ны өдрийн Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд оролцсон. | | |
| 2 | Төрийн албаны сургалтад хамрагдана | Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | - | Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын Академиас зохиодог Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2025 оны 02 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд хамрагдан суралцаж төгссөн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 95% |

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Төмөр Баясгалан /......................................................./ Огноо: .........................

ТУ32861 6806236 9022010236

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн,

Хишигдэлгэр Даваадорж /......................................................./ Огноо: .........................